

“ЗӨӨЛӨН ХҮЧ”-НИЙ БОДЛОГО БА МОНГОЛ УЛС

Ш.Батболд¹

Abstract: *The term “Soft power” was first introduced to modern political science, particularly international relations by Joseph S.Nye, a Professor at Harvard University, United States in 1990. Soft power policy indicates a non-coercive and cost-effective political method that uses culture, political values and foreign policy to influence others and achieve the desired goal. Thus, soft power today has become an imperative part of the foreign policies of the most countries, especially those countries with leading policies and intentions to lead, and a contention to yield results with the use of soft power is developing. Due to the effects of globalization, the interrelations between countries have increased and it has become costly to solve problems by military force or through economic pressure, and this factor signifies the relevance of the soft power.*

As the world actively studies soft power on an academic and policy level, and makes various steps towards its practical implementation, Mongolia shouldn't be excluded. In other words, there is a crucial need for intensifying the study on soft power policy, making it known to the decision-makers and using it to promote Mongolia abroad. On the other hand, foreign countries' soft power policies are being implemented vigorously in Mongolia. The article reflects on some suggestions about the ways to realize Mongolian soft power policy and counterbalance this influence.

Түлхүүр үг: Уламжлал, үнэт зүйл, бодлого, нөлөөлөл, үр дүн

Орчин үеийн улс төрийн шинжлэх ухаан, тэр дотроо олон улсын харилцааны онолд АНУ-ын Харвардын их сургуулийн профессор Жозеф Жорж Сэмуэл Най “Зөөлөн хүч” буюу Soft power гэх нэр томъёог 1990 онд анх оруулж ирсэн байна. Энэхүү “Зөөлөн хүч” гэдэг нь албадлага, заналхийллээр бодлогоо тулгахаас зайлсхийсэн, өртөг зардал багатай, хэл соёл, улс төрийн үнэт зүйл, гадаад бодлогын

1. МОНЦАМЭ агентлагийн орлогч дарга, batbold_sh@yahoo.com

манлайллаар бусдыг урвуулан татаж нөлөөлөлдөө оруулах, улмаар хүссэн үр дүндээ хүрэх улс төрийн бодлогын арга юм.

Жозеф Най 1990 онд бичсэн “*Bound to lead: The Changing Nature of American Power*” /Манлайллын төлөөх эрс алхам: Америкийн эрх мэдлийн өөрчлөгдөж буй дүр төрх/ номдоо “Зөөлөн хүч” гэдэг нь хүссэн үр дүндээ хүрэхийн тулд бусдын зан байдалд соёлын хандлагад нь тулгуурлан нөлөөлөх аядуу бодлого”² гэсэн бол 2004 онд хэвлүүлсэн “*Soft power: The Means to Success in World Politics*” /Зөөлөн хүч бол дэлхийн улс төрийн амжилтад хүрэх арга хэрэгсэл/ номдоо “Зөөлөн хүч”-ний бодлогыг

1.Соёл

2.Улс төрийн үнэт зүйлс

3.Гадаад бодлого гэсэн гол тулгуур баганатай “Бусдыг сонголт хийхэд хүргэх чадвар юм”³ дэлгэрүүлэн тодорхойлжээ.

Өнөөдөр ихэнх улс орнууд, тэр тусмаа дэлхийд бодлогоороо тэргүүлэгч, тэргүүлэхийг хүсэгч орнуудын гадаад бодлогын нэг салшгүй хэсэг нь “Зөөлөн хүч” болж, түүнийг ашиглан үр дүнд хүрэх тухай эрмэлзэл, өрсөлдөөн өрнөж байна. Даяаршлын нөлөөгөөр улс орнуудын харилцан хамаарал нэмэгдэж, аливаа асуудлыг цэргийн хүч, эсвэл эдийн засгийн дарамт шахалт, татаасаар шийдвэрлэхэд маш их өртөг зардалтай болсон нь ч “Зөөлөн хүч”-ний ач холбогдлыг улам нэмэгдүүлж байгаа юм.

Дэлхий нийтээрээ ийнхүү “Зөөлөн хүч”-ийг эрдэм шинжилгээ, бодлогын түвшинд идэвхтэй судлаж, практик дээр хэрэгжүүлэх төрөл бүрийн алхмууд хийж байгаа тул Монгол Улс ч уг асуудлын гадуур үлдэх ёсгүй. Өөрөөр хэлбэл, “Зөөлөн хүч”-ний бодлогын судалгааг гүнзгийрүүлэх, шийдвэр гаргагчдад ойлгуулан улс орноо гадаад ертөнцөд сурталчлан таниулахад ашиглах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Нөгөө талаар гадны улс орнуудаас манай улсад явуулж буй “Зөөлөн хүч”-ний бодлогын нөлөөллийг саармагжуулах арга замыг ч хайх цаг иржээ.

2. Joseph S. Nye. Bound to Lead: The Changing Nature of American Power. New York., 1990.

3. Joseph S. Nye. Soft Power: The Means to Success in World Power. New York., 2004.

“ЗӨӨЛӨН ХҮЧ”-НИЙ БОДЛОГО БА МОНГОЛ УЛС

2. Монголоос “Зөөлөн хүч”-ний бодлогыг хэрэгжүүлэх боломж

Монгол Улс бол нүүдлийн соёл, уламжлал, түүхэн баялаг замналтай, түүнийг нь дэлхий дахинаа сонирхдог, орчин үед олон улсын тавцанд нөлөөтэй байхыг эрмэлзэж буй орон. Нөгөө талаараа байгалийн арвин баялаг нөөцөөрөө дэлхийн хүчирхэг гүрнүүдийн анхааралд ороод буй.

Сүүлийн жилүүдэд олон улсын харилцаа эрчимтэй өөрчлөгдөж, даяаршлын үйл явц хүрээгээ улам бүр тэлж, улс хоорондын харилцан хамаарал гүнзгийрч байна. Ийм нөхцөлд үндэсний түүх-соёлоо дээдлэн, түүх, соёл, урлагийн уламжлал, нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, спортын салбарын ололт амжилт, оюун санааны үнэт зүйлсээ дэлхий нийтэд сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэх чиглэлд бид эрчимтэй ажиллах ёстой. Гадаад дахь нөлөөллийн бүсээ өргөжүүлэх, эдийн засгийн эргэлт бий болгон баялаг бүтээхэд чиглэсэн улс төр, гадаад харилцаа, олон нийтийн болон соёлын дипломат ажиллагаанд тулгуурласан “Зөөлөн хүч”-ний бодлого Монгол Улсын хувьд чухал юм.

“Зөөлөн хүч”-ний бодлого явуулах үндсэн суурь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол Улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлого зэрэг баримт бичгүүдэд туссан байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 7.2-д “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна”, 10.1-д “Монгол Улс олон улсын эх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна”⁴, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.4.6-д “Үндэсний түүх, хэл, соёл, шашин, зан заншил, уламжлалаа таниулах, эх оронч үндэсний үзлийг төлөвшүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн”, 3.1.4.7-д “Дэлхийн бусад орон, түүний дотор гуравдагч хөрш орнуудтай соёлын салбарт өргөн харилцаа хөгжүүлж, дипломат төлөөлөл, иргэдээрээ дамжуулан монгол үндэстний соёл, түүхийг дэлхий дахинаа сурталчлах ажлыг эрчимжүүлнэ”⁵, Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалын

4. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992.

5. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Монгол Улсын төрийн бодлогын баримт бичгүүд. УБ., 2011.

7.29.1-д “Монгол Улсын түүх соёлын уламжлал, эдийн засаг, нийгмийн салбарын ололт амжилтыг гадаадад сурталчлах үйл ажиллагааг идэвхжүүлэх”⁶, Монгол Улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлогод “Үндэсний соёл, урлагийг дэлхий нийтэд сурталчлан таниулах, монгол соёлын нөлөөллийг өргөжүүлэх, давтагдашгүй чанарыг баталгаажуулах”⁷ гэж заажээ.

Эдгээрт үндэслэн Монгол Улсын Засгийн газраас “Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр”-ийг 2016 оны 1 дүгээр сард баталлаа. 2016-2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын “Зөөлөн хүч”-ийг бий болгох асуудлыг тусгайлан тусгаснаараа онцлог юм.

Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн энэ тухай “Сүүлийн жилүүдэд *“Soft power”* буюу “Зөөлөн хүч”-ний бодлого гадаад бодлогын чухал ойлголт болоод байна. “Зөөлөн хүч”-ний бодлогын цөм болсон соёлын харилцаагаар дамжуулан улсаа сурталчлах, имиж бүрдүүлэх, үндэстнийг брэндчилэх, соёлын өвийг таниулах чиглэлээр хийсэн, хийж байгаа ажлуудаа уялдуулах, гадаад сурталчилгааны нэгдсэн бодлого хэрэгжүүлэх шаардлага бий болсон”⁸ хэмээжээ. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Засгийн газраас “Зөөлөн хүч”-ний асуудалд анхаарч, ажил хэрэг болгох алхмыг хийгээд байна.

Хөтөлбөрийн дагуу тэргүүн ээлжинд түүх, соёл урлаг, аялал жуулчлал, спорт, олон улсын арга хэмжээ, үндэсний брэнд бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний чиглэлээр гадаад улс орнууд руу чиглэсэн гадаад сурталчилгаа буюу “Зөөлөн хүч”-ийг явуулахаар төлөвлөжээ⁹.

Түүх, соёл урлаг, үндэсний брэнд бараа, бүтээгдэхүүнээр дамжуулан “Зөөлөн хүч” бий болгох тухайд юуны түрүүнд хоёр хөрш ОХУ болон БНХАУ-д Монгол Улсын соёл, мэдээллийн төвтэй болж, түүндээ Монголыг сурталчлах үйл ажиллагааг тасралтгүй явуулах зайлшгүй шаардлагатай байна.

6. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. Монгол Улсын төрийн бодлогын баримт бичгүүд. УБ., 2011.

7. Монгол Улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлого. Монгол Улсын төрийн бодлогын баримт бичгүүд. УБ., 2011.

8. Л.Пүрэвсүрэн: Монгол Улсыг түүх, урлаг соёл гэдэг зөөлөн хүчний бодлогоор дэлхийд сурталчилна. <http://sonin.mn/news/politics-economy/56832>

9. Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр. УБ., 2016.

“ЗӨӨЛӨН ХҮЧ”-НИЙ БОДЛОГО БА МОНГОЛ УЛС

Манай улс БНХАУ-ын Бээжин, Хөххотод Соёлын төвтэй болох асуудал сүүлийн жилүүдэд яригдаж байгаа ч өнөөдрийг хүртэл ажил хэрэг болж чадаагүй байна. Хамгийн сүүлд БНХАУ-ын дарга Ши Жинпинийг манай улсад айлчлах үеэр 2014 онд гаргасан Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглалд “Монголын тал Бээжинд соёлын төв байгуулахад Хятадын талаас шаардлагатай тусламжийг үзүүлнэ” гэж тусгасан нь угтаа бид өөрсдийн улсаа сурталчлах ажилд Хятадын талаас мөнгө гаргуулах тухай юм.

Хэдийгээр манай улс эдийн засгийн хувьд боломж муутай байгаа ч дээр нь эрх бүхий албан тушаалтнуудын санаачилга, хөөцөлдлөгөө дутагдаж байгаа нь ажиглагдаж байна. Хятадын тал мөнгө гаргавал энэ нь Монголын биш Хятадын “Зөөлөн хүч” болж хувирах аюул үүний цаана байгааг ч анхаарах ёстой болов уу. Ер нь бид өөрсдөө зорилготой, санаачилгатай, мөнгө санхүүгийн асуудлаа шийдэж байж л бодлого маань бидэнд ашигтайгаар хэрэгжинэ гэдгийг анхаарах хэрэгтэй юм.

Цаашлаад дэлхийн голлох орнуудад ийм мэдээллийн төвүүдтэй болох нь чухал байна. Ялангуяа Монгол Улс нь монгол үндэстний гол цөм, төвийн хувьд хилийн чанадад амьдардаг монголчууддаа нөлөөлөл үзүүлэх асуудал их чухал учраас Өвөрмонгол, Буриад, Халимагт Монголын соёлын төвтэй болох нь элэг нэгтнүүддээ “Зөөлөн хүч”-ээр нөлөөлөхийн зэрэгцээ хэл, соёл, түүх, өв уламжлалаа үе улируулан өвлүүлж, хадгалж үлдэх алсын бодлогын эхлэл болно.

Энэ агуулгаараа Монголын Засгийн газраас “Монголын соёлын төв”-ийг бүхий л бололцоогоо дайчилж олноор байгуулан тогтмол үйл ажиллагаанд оруулах нь Монголын “Зөөлөн хүч”-ний гол чиглэл болох ёстой.

Монгол Улс нэгэнт монгол туургатны төв болохын хувьд “Зөөлөн хүч” болгож ашиглаж болох нэг гол арга хэрэгсэл байгаа нь буддын шашин юм. Буддын шашин бол Манжийн үеэс нэгдмэл байдлаа алдсан монгол угсаатны нэгдэл нягтралыг эргүүлэн бий болгоход чухал байр суурь эзэлнэ. Ийм нэгдэл бий болгож чадвал гадны шашнаар дамжсан “Зөөлөн хүч”-ний нөлөөллийг ч саармагжуулах ач холбогдолтой. Монголчууд сүүлийн жилүүдэд, ялангуяа хоёр улсын

хооронд визгүй зорчих болсон 2014 оноос хойш ОХУ-ын Буриад улсад буй Итгэлт хамбын ариун лагшинд мөргөхөөр явах болсон. Энэ нь эдийн засгийн агуулгаар нь харахад манайхан мөнгөөрөө тэдний нэг бүс нутгийн хөгжлийг зарим талаар дэмжиж буй мэт харагдаж байгаа ч нөгөө талаараа мөргөлд оролцогчдоор дамжин монгол хэл, соёлын элементүүд олон жил Оросын харьяанд байсан буриадуудад хүрч байгаа, тэдний “монгол хүн” гэх сэтгэлийн увидсыг хөндсөн, үүгээрээ эргээд монгол уламжлал, сэтгэлгээгээ сэргээх ач холбогдолтой байна. Наад зах нь Итгэлт хамбын ариун лагшин буй Иволгын дацангийн эргэн тойронд монгол нэртэй хоол, цайны газрууд олноор бий болж, тэнд монгол үндэсний хоолоо хийж нийтэд үйлчилдэг болсон байна. Цаашлаад Улаан-Үд хотод ч энэ хандлага дэлгэрч байна. Энэ хавийн бүс нутагт байнга монголчууд зорчих болсноор үндсэндээ хэл, бичгээ мартахад хүрээд байсан буриад зоны сэтгэлгээг ч өөрчилж байна. Өөрөөр хэлбэл, Итгэлт хамба монголчуудын “Зөөлөн хүч” болж байна. ОХУ-ын Санкт-Петрбургт буй буддын сүм, Халимагт буй Европ дахь цорын ганц буддын төв зэргийг ашиглан монгол лам нараа оролцуулсан үйл ажиллагаа явуулж Монголыг сурталчлах боломж байгааг эндээс харж болно.

Нөгөө талаар БНХАУ дахь монгол үндэстнүүдийн сүм хийд үндсэндээ үйл ажиллагаа хязгаарлагдмал, үзмэрийн хэмжээнд очсон. Ийм нөхцөлд монгол туургатны шашны төв Монгол Улс болох боломжтой. Учир нь манайд уламжлалт шашин маань ямар ч хяналт, хязгаарлалтгүй. Эрдэнэ зуу, Гандантэгчилэн, Амарбаясгалант зэрэг томоохон төвүүдтэй. Эдгээр боломждоо түшиглэн 10-р Богд Жавзандамбын дүрээр монгол хүнийг тодруулж чадвал нийт монгол туургатнаа татах, улмаар тэдний эргэл мөргөлөөр дамжуулан түүх, уламжлал, хэл соёлоо өвлүүлэн соёлын солилцоо хийх, энэ нь “Зөөлөн хүч” болох нэг хүчин зүйл болно. Сүүлийн жилүүдэд ихээр яригдах болсон 10-р Богдыг Монголоос тодруулахын эдийн засаг, нийгэм соёлын ач холбогдлыг зарим судлаач “Монголчууд оюун санааны нэгдмэл үнэт зүйлтэй болж, үндэсний дархлаа баталгаажина. Хилийн чанадад байх монгол угсаатныг оюун санааны хувьд таган чангаа бодит хүчин зүйлийг бий болгоно. Монголчуудынхаа дэмжлэгийг хүлээсэн монгол угсаатны нэгдмэл хүчирхэг соёлын ижилслийг

“ЗӨӨЛӨН ХҮЧ”-НИЙ БОДЛОГО БА МОНГОЛ УЛС

чангатгана. Монголчууд оюун санаа, итгэл үнэмшлийн нэгдмэл үнэт зүйлтэй болсноор Утай, Гүнбэн, Итгэлт хамба руу чиглэсэн урсгалыг зогсоож, хэтдээ дотоод гадаадаас Богд руу чиглэсэн шашин соёлын шинэ урсгалыг бий болгоно”¹⁰ хэмээн дүгнэж байгаа нь үүнийг бататгана.

“Зөөлөн хүч” болгох дараагийн нэг арга хэрэгсэл нь гадаад оюутнуудыг Монголд олноор сургах, улмаар тэднээр дамжуулан улс орноо гадаад ертөнцөд таниулах. БСШУЯ-ны гаргасан статистикаас харахад манай улсын дээд боловсролын байгууллагад суралцдаг гадаад иргэдийн тоо 2008-2009 онд 1106 байсан бол 2013-2014 оны хичээлийн жилд 1130 байжээ¹¹. Эдгээрийн ихэнх нь хувийн зардлаар суралцагсад аж. Нэгэнт гадаадаас суралцагсад тухайн орныхоо талаар эерэг сэтгэгдэлтэй үлддэг, энэ нь “Зөөлөн хүч” болгож ашиглах үндэс суурь болдог нь олон орны туршлагаас харагдсан болохоор цаашид гадаад оюутнуудыг Монголд өргөнөөр сургах хөтөлбөрийг Засгийн газраас хэрэгжүүлэх боломжийг мөн эрж хайх хэрэгтэй. Үүнийг МУИС, ХААИС, МУБИС зэрэг үндэсний томоохон их сургуулиуддаа тулгуурлан хийх боломжтой юм.

Олон улсын арга хэмжээгээр дамжуулж “Зөөлөн хүч” бий болгох алхмыг ирэх 7 дугаар сард зохион байгуулах гэж буй АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтаар эхлүүлэх гэж байна. АМЕМ нь олон улсын болон бүс нутгийн хурал, семинар, чуулган, ажил хэрэгч арга хэмжээ зохион байгуулах чадавх, дэд бүтэц Монгол Улсад бүрдэхэд тустай. Ингэснээр ажил хэрэгч /улс төрийн/ аялал жуулчлалын том үүд хаалга, дэд бүтцийг Монголд нээнэ. АСЕМ-ыг зохион байгуулсан туршлагадаа тулгуурлан цаашлаад Монгол Улсын санаачилсан “Талын зам” төсөл, “Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачилгыг хэрэгжүүлэх гэх мэтээр өөрсдийн бололцоонд нийцүүлэн олон улсын томоохон хурал, арга хэмжээ, төрөл бүрийн бие даасан болон хамтарсан экспо зэргийг тасралтгүй зохион байгуулах нь түүнд оролцогчдоор дамжуулан улс орныхоо бодлого зорилт, түүх, соёл, уламжлал, үнэт зүйл, өнөөдрийн ололт амжилтаа сурталчлах гол арга хэрэгсэл болох юм.

10. Базардорж Д. Богдын дараагийн дүрийг тодруулах асуудалд. Pax Mongolica. №1. 2015.

11. БСШУЯ-ны статистик. УБ., 2013.

Урлаг, спортын алдартнууд, нэр цуутай хүмүүсээр дамжуулан эх орноо сурталчлах ардын дипломатын арга ч “Зөөлөн хүч” болдог бөгөөд сумогийн их аварга Хакухо М.Даваажаргал, Олимпын аварга Н.Түвшинбаяр, АНУ-д ажиллаж амьдарч буй МУГЖ, балетчин Д.Алтанхуяг, дуурийн урлагаар дэлхий дахинаа Монголынхоо нэрийг дуурсгаж яваа дуучин МУГЖ Э.Амартүвшин, Г.Ариунбаатар нарыг Монгол Улсын Гадаад хэргийн яамнаас “Соёлын элч”-ээр томилсон нь энэ төрлийн ажлын эхлэл болж байна. Энэ ажил цаашид тасралтгүй үргэлжлэх учиртай.

Монголын түүх, өв соёл, уламжлал, зан заншлыг өвөрмөгц байдлаар харуулсан болон өнөөдрийн хөгжил цэцэглэлтээ таниулсан уран сайхны ба баримтат киног дэлхийн шилдэг кино компани, алдартай найруулагч, жүжигчидтэй болон өөрийн орны уран бүтээлчидтэй хамтран хийж, дэлхийн зах зээлд гаргах боломж бас бидэнд байна. Найруулагч Д.Бямбасүрэнгийн Германы уран бүтээлчидтэй хамтран хийсэн “Ингэн нулимс” кино Оскарын шагналд өрсөлдөж, чамлахааргүй амжилт олсон туршлага бий. Хэдийгээр Хятадын бодлогоор хийгдсэн ч “Чонон сүлд” кино дэлхийд Монголыг сонирхох сонирхол ямар их байгааг харуулсан. Ардын урлагийн хамтлагууд, морин хуур, уртын дуу, уламжлалт болон орчин үеийн уран зураг, хөгжим зэрэг Монголын “Зөөлөн хүч” болгож ашиглах өгөгдлүүд бидэнд чамлахааргүй байна.

Мөн “Зөөлөн хүч”-ний бодлогыг гадаад ертөнцөд түгээн дэлгэрүүлэх гол хэрэгсэл болдог хэвлэл мэдээллийн хүчирхэг хэрэгслүүдтэй болох ёстой.

Наад зах нь англи хэлээр Монгол Улсын тухай тогтмол мэдээ мэдээлэл, нэвтрүүлэг цацдаг гадаад сурталчилгааны телевизийн сувгийг төрийн дэмжлэгээр бий болгох зайлшгүй шаардлага бий болсон. Уламжлалт байдлаар гадаад сурталчилгаандаа ашиглаж ирсэн мэдээллийн МОНЦАМЭ агентлаг, МҮОНР-гийн дэргэдэх “Монголын дуу хоолой радио”-гийн үйл ажиллагааг төрөөс бодлогоор дэмжин нийтлэл, нэвтрүүлгийн болон боловсон хүчин, техник технологи, менежментийн шинэчлэл хийж ажиллуулах хэрэгтэй гэдэг нь ч харагдаж байна.

“ЗӨӨЛӨН ХҮЧ”-НИЙ БОДЛОГО БА МОНГОЛ УЛС

Монголд ирсэн гадаадын жуулчдаар дамжуулан улсаа сурталчлах боломж бас байна. Хамгийн гол нь жуулчдад үзүүлж, харуулдаг зүйлсээ сонирхолтой, монгол уламжлал, өв соёлоо орчин үетэй чадварлаг хослуулсан, “Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр”-ийн агуулгатай уялдуулах шаардлага байна. Ийм уялдааг хангах зорилгоор “Зөөлөн хүч”-ний бодлогоор тэргүүлэгч улс орнуудын адил “Зөөлөн хүч”-ний бодлого хариуцсан агентлагтай болоход ч болохгүй зүйлгүй юм.

2. Монгол дахь гадны “Зөөлөн хүч”-ний бодлогын нөлөөлөл

Монгол Улсад гадны улс орнуудын “Зөөлөн хүч”-ний бодлогын нөлөөлөл байна уу? Байгаа бол ямар улсууд бидэнд бодлогоо тулгаж байна вэ? Тэр нь манай нийгмийн харилцаанд нөлөөлж байна уу? Гэх мэтээр асуугаад үзэхээр манай улсад гадны “Зөөлөн хүч”-ны нөлөөлөл байгаагаар барахгүй зарим талаараа түүний нөлөөллөөс сэрэмжлэх хэмжээнд хүрчээ. Энэхүү өгүүлэлд манай улсад бодлогын нөлөөлөл нь бодитоор мэдрэгдэж буй зарим орныг жишээлэн авч үзэв.

Америкийн Нэгдсэн Улс: АНУ-ын соёл, эдийн засаг нь өөрөө “Зөөлөн хүч” болдог онцлогтой. Учир нь Америк соёл дэлхийг бүхэлд нь хамарсан үнэт зүйл, ашиг сонирхлыг бий болгосон шинж чанартай байдаг бол эдийн засгийн хөгжил, тэрхүү хөгжилд хүрсэн арга зам, эдийн засгийн загвар нь бусад улсад түүнээс суралцаж амжилтад хүрэх эрмэлзлийг бий болгож, олон улсад АНУ-ын нэр хүндийг өсгөж байдаг¹² давуу талтай. Энэ агуулгаараа АНУ-ын “Зөөлөн хүч” бол сүүлийн хэдхэн жилд бий болчихсон юм биш. Бага буурай орны залуусыг тэтгэлгээр эх орондоо сургах, эргүүлэн нутагт нь удирдагч болоход нь дэмжлэг үзүүлж бодлогоо хэрэгжүүлэх зэргээр ялангуяа колонийн задралын дараах Ази, Африкийн орнуудад “Зөөлөн хүч”-ийг хэрэглэж ирсэн туршлагатай.

Монгол Улсын олон мянган хүний, тэр дотроо ихэнх залуусын мөрөөдөл англи хэл, “Америк мөрөөдөл” болж, аав ээж, ах дүү, хамаатан садангийн хэн нэг нь АНУ-д ажиллаж амьдардаг, суралцдаг зэргээс үзэхэд өнөөдөр АНУ-ын “Зөөлөн хүч”-ний нөлөөлөл анхаарал тавих хэмжээнд хүрчээ. Тус улсын “Зөөлөн хүч”-ний бодлогоо

12. Бямбаханд Л. Монгол Улсын “Зөөлөн хүч”-ийг бий болгох боломж, АНУ-ын туршлага. Стратегийн судалгаа №63 (3/2013).

хэрэгжүүлдэг Дэлхийн банк, Олон улсын валютын сан, “Азийн сан”, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Америкийн олон улсын хөгжлийн агентлаг /USAID/, Америкийн соёл, мэдээллийн төв /Улаанбаатар болон Ховд аймагт/, Энхтайвны корпус, Соросын сангаас санхүүждэг Нээлттэй нийгэм форум зэрэг байгууллагууд бүгд манай улсад үйл ажиллагаагаа явуулж, тэднээр дамжин АНУ-ын бодлогыг дэмжих төсөл хөтөлбөрүүд /ардчилал, хүний эрх, ардчилсан сонгууль, жендерийн тэгш байдал, сонгогчийн боловсрол г.м/ тасралтгүй хэрэгжиж, боловсрол, соёлын солилцоо бодитой явагдаж байна. Манай улсад тухайлбал,

1. Засаглалын хувьд ардчилсан засаглал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг тунхагласан.
2. Боловсролыг дэмжих хүрээнд англи хэл, тэтгэлэгт хөтөлбөрүүдээр дамжсан боловсролын солилцоо тогтмол хийгдэж байна.
3. Соёл урлагаар дамжсан кино, дуу хөгжим болон бусад нийтийн болон ахуйн соёлын солилцооны шинэ үе ирсэн.
4. Технологийн бүтээгдэхүүн буюу компьютер, гар утас, таблет, интернетийн хэрэглээгээр нэвтэрсэн АНУ-ын “Зөөлөн хүч”-ний бодлогийн нөлөөлөл бодитой байна.

АНУ-ын Энх тайвны корпус нь Монгол Улсад 1991 оноос үйл ажиллагаа явуулж буй бөгөөд Англи хэл, Олон нийтэд түшиглэсэн эрүүл мэнд, Эдийн засгийн хөгжил, Хүүхэд, залуучууд-орон нутгийн хөгжил гэсэн 4 хөтөлбөр хэрэгжүүлдэг.

АНУ-ын Засгийн газрын санхүүжүүлэлт бүхий

- Фулбрайтын гадаад оюутны хөтөлбөр
- Фулбрайтын шинжлэх ухаан технологийн тэтгэлэгт хөтөлбөр
- Фулбрайтын гадаад хэлний туслах багшийн хөтөлбөр
- Хьюбэрт Хамфрийн тэтгэлэгт хөтөлбөр
- Бакалаврын шатны солилцооны хөтөлбөр (Глобал ЮГРАД)
- Эйзенхауерын тэтгэлэгт хөтөлбөр
- Олон улсын манлайлагчдыг АНУ-тай танилцуулах хөтөлбөр

“ЗӨӨЛӨН ХҮЧ”-НИЙ БОДЛОГО БА МОНГОЛ УЛС

- АНУ-ын дээд сургуулийн судалгааны хөтөлбөр зэрэг солилцооны хөтөлбөрүүдэд 1989 оноос хойш манай улсын 1200 гаруй оюутан хамрагдаж, тус улсад суралцжээ. Суралцагчдын ихэнх нь одоо төр засаг, яам тамгын газар, эрх баригч намуудын удирдлагад буюу бодлого боловсруулж, шийдвэр гаргах түвшинд ажиллаж байна.

Манай улсын жил бүрийн Төсвийн тухай хуулийн төслийг Дэлхийн банкны зөвлөгөөгөөр боловсруулж баталдаг, ОУВС төсөв, мөнгөний бодлогыг хэрхэх зөвлөгөөг Монголбанк, Сангийн яаманд тогтмол өгдөг болсоор 20 гаруй жил өнгөрч байна.

Оросын Холбооны Улс: ОХУ-ын зүгээс явуулж буй “Зөөлөн хүч”-ний бодлого социалист системийн үеийнхийгээ бодвол багассан. Гэхдээ 1990-ээд он, 2000-аад оны эхний үеэ бодвол идэвхжиж байна. Манай улсад ОХУ-ын “Зөөлөн хүч”-ийг хэрэгжүүлэгч “Россотрудничество” агентлагийн төлөөлөгчийн газар ажиллаж, түүний дор Оросын боловсрол, соёл, шинжлэх ухааны төв /ДЦНК/ , “Русский мир” сан зэрэг байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. Плехановын нэрэмжит эдийн засгийн дээд сургууль зэрэг ОХУ-ын зарим их дээд сургуулийн салбар Улаанбаатар хотноо нээгдлээ. Үүнийг дагаад орос хэл сурах сонирхолтой, уг хэлээр суралцдаг иргэдийн тоо нэмэгдэж, энэ эрэлтээ дагаад орос хэлээр сургалт явуулдаг сургууль, цэцэрлэг нэмэгдэж байна. ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин 2014 онд манай улсад айлчлах үеэр орос хэлээр сургалт явуулдаг сургууль, цэцэрлэгийн тоог цаашид ч нэмэгдүүлнэ, үүнд ОХУ-ын талаас хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай хэлэлцсэн. ОХУ-ын Засгийн газрын болон “Оросын төмөр зам”, “РосАтом”, “Роснефть” зэрэг компанийн тэтгэлгээр суралцагчдын тоо мөн жил ирэх тусам өсч, хоёр орон харилцан визгүй зорчдог болсноор иргэд хоорондын солилцоо, хуралдааны эргэлт нэмэгдэх хандлага бий болжээ.

2016 оны байдлаар ОХУ-д соёл урлаг, зэвсэгт хүчин, эдийн засаг, инженер техник, хууль эрх зүй, хүмүүнлэг, анагаах ухааны салбаруудад ойролцоогоор 1650 оюутан тэтгэлэгтэй суралцаж байна.

2014 онд ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр тус улсад жилдээ 226 оюутан суралцуулж байсан бол 2016 онд нийт 376 хуваарьт

оюутан суралцуулахаар болжээ¹³. Мөн “Оросын төмөр зам” компани 40, “РосАтом” компани 20, “Роснефть” компани 10 оюутныг жил бүр тэтгэлгээр суралцуулдаг байна.

Монгол иргэдийн зүгээс ОХУ, орос иргэдэд ханддаг уламжлалт найрсаг сэтгэлгээ өнөө хүртэл хэвээрээ байгаа нь манай улс дахь ОХУ-ын явуулж буй “Зөөлөн хүч”-ний бодлогын үр нөлөөг дээшлүүлдэг хандлага ч бас ажиглагдаж байгаа юм. Тухайлбал, “Сант Марал” судалгааны төвөөс 2016 оны 3-р сард судалгаа хийхдээ оролцогчдоос “Монголын хамгийн сайн түнш орон” гэсэн асуултад хариулт авахад хөдөөнөөс оролцогчдын 85.7 %, Улаанбаатараас оролцогчдын 75.8 % буюу нийт дүнгээрээ асуултад хариулсан хүмүүсийн 81.4 % нь “Орос” хэмээн хариулсан байгаа юм. Мөн тэднээс “Таны бодлоор аль улсын иргэдтэй нь монголчууд эвтэй, хэл амаа олж, ажиллаж чадаж байна вэ” хэмээн асуухад хөдөө 63.3%, Улаанбаатарт 56.1 %, нийт 60.2 % нь бас л “Орос” гэжээ¹⁴. Иргэд ОХУ-ын дараа л БНХАУ, АНУ, Япон, Өмнөд Солонгосыг нэрлэсэн байна.

Эндээс манай иргэдийн уламжлалт найрсаг хандлагад тулгуурлан ОХУ-ын “Зөөлөн хүч” цаашид улам өсөх дүр зураг харагдаж байгаа юм.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс: Манай улсад явуулж буй өмнөд хөрш БНХАУ-ын “Зөөлөн хүч”-ний бодлого нь эдийн засаг, соёл, боловсролын чиглэлд түлхүү чиглэж байна. Зөвхөн эдийн засгийн нөлөөллөөр нь аваад үзэхэд л 1990 оноос хойш эдийн засаг, худалдааны эргэлтийн хувьд Монгол Улс БНХАУ-аас шууд хамааралтай болсон, БНХАУ нь манай гадаад худалдааны хамгийн том түнш юм. 1990 онд хоёр талын хооронд хийгдсэн худалдааны хэмжээ дөнгөж 33,6 сая ам доллар байсан бол 2014 оны үзүүлэлтээр 6.2 тэрбум ам.доллар болж бараг 370 дахин өссөн байна. 2014 онд байгуулсан Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглалд 2020 он гэхэд хоёр орны худалдааны хэмжээг 10 тэрбум ам.долларт хүргэх зорилт тавьсан.

Хоёр орны бараа эргэлт 2014 онд 6,8 тэрбум ам.долларт хүрч, Монгол Улсын нийт экспортын 83,3 хувь, импорт 33,8 хувийг эзлэж байна.

13. <http://www.meds.gov.mn/Ru1617>

14. Сант Марал. Улс төрийн барометр №15/49/, 2016 оны 3 дугаар сар.

“ЗӨӨЛӨН ХҮЧ”-НИЙ БОДЛОГО БА МОНГОЛ УЛС

Хөрөнгө оруулалтын хувьд ч Монгол Улсад оруулсан гадаадын хөрөнгө оруулагч орнуудыг Хятад Улс сүүлийн 10 гаруй тэргүүлж ирсэн. 2014 онд Монгол Улсад оруулсан гадаадын хөрөнгө оруулалт 507 сая ам.долларт хүрсэн бол үүний 210 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг 2014 онд БНХАУ-аас Монгол Улсад оруулсан хэмээн Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яамнаас мэдээлжээ¹⁵.

Хөнгөлөлттэй зээл, хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжийн хувьд ч БНХАУ-ын хувь оролцоо багагүй бөгөөд энэ агуулгаараа эдийн засгийн нөлөө нь бодитой байна.

Хятадын “Зөөлөн хүч”-ний гол хэрэгсэл Күнзийн институт гэхэд манай улсын МУИС, МУБИС, Ховд их сургууль дээр байгуулагдсан. Хятадын соёлын төв 2010 оноос Улаанбаатарт ажиллаж төрөл бүрийн урлаг, соёлын арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. Хятад хэлний сургалттай сургууль, цэцэрлэгийн тоо ч жил ирэх бүр нэмэгдэж байгаа бөгөөд тэдний ихэнх нь өмнөд хөршөөс хөрөнгө оруулалттай байна.

Хятадын Засгийн газрын тэтгэлэг, ӨМӨЗО-ы Засгийн газрын тэтгэлэг, Шанхайн Засгийн газрын тэтгэлэг гэх мэт маш олон тэтгэлэгт хөтөлбөрүүд манай улсад зарлагддаг, эдгээрт бакалавр, магистр, докторын болон мэргэжил дээшлүүлэх сургалтад жил бүр 700-800 хүн хамрагддаг ажээ. 2016 онд л гэхэд зөвхөн БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлгээр 197 хүнийг магистр, докторын түвшинд, 123 хүнийг бакалаврын түвшинд суралцуулахаар болжээ¹⁶.

Монгол Улсаас гадаад орнуудад суралцаж байгаа оюутны тоогоор Хятад улс 1-рт ордог бөгөөд 2016 оны байдлаар БНХАУ-д 10 мянган гаруй монгол оюутан суралцаж байгаагийн 7000 гаруй нь тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсад ажээ.

Энэ нь Хятад улс уламжлал, шинэчлэлийг хослуулсан их гүрний хувиар боловсролын салбараар дамжуулан Монголын ирээдүйн сэхээтнүүдийн нэлээд хэсгийг Хятадад боловсрол эзэмшүүлснээр наанадаж тэдэнд Хятад улсад нааштай ханддаг сэтгэлгээг төлөвшүүлж, цаашлаад тэднээр дамжуулан Хятадын соёлыг түгээн дэлгэрүүлэх гэх

15. <http://www.beijing.mfa.gov.mn/>

16. <http://www.meds.gov.mn/chinaBachelor2016>, <http://www.meds.gov.mn/chinaMASDOC2016>

мэт олон зорилготой байхыг үгүйсгэхгүй¹⁷.

2014 онд манай улсад айлчилсан БНХАУ-ын дарга Ши Жинпиний айлчлалын үеэр ирэх 5 жил Хятадын Засгийн газрын тэтгэлгээр суралцагчдын тоог 1000-аар нэмэгдүүлэх, богино хугацааны сургалтын 1000 квот олгох, хэвлэл мэдээллийн 250 төлөөлөгчийг Хятадад айлчлуулах, жил бүр Монголын 100 залууг Хятадад хүлээн авч танилцах аялал зохион байгуулах, Хятадын кино дэлгэцийн шилдэг 25 бүтээлийг үнэ төлбөргүй Монголын талд өгөх гэх мэт хамтын ажиллагааны механизмыг тохирсон¹⁸ нь тус улсын боловсрол, соёлын нөлөөллийг улам нэмэгдүүлэх алхам болов.

Энэ хандлагаар харахад нэг үе монголчууд орос хэл, орос соёлын нөлөөлөлд автсан шиг удахгүй хятад хэл, хятад соёлын нөлөө тогтохыг үгүйсгэх аргагүй юм.

Бусад улсын “Зөөлөн хүч”-ний нөлөө: “Зөөлөн хүч”-ний бодлого нь манай улсад тодорхой хэмжээнд нөлөөтэй харагдаж буй дараагийн улсууд бол БНСУ, Япон, ХБНГУ, БНТУ юм.

БНСУ-ын олон ангит кино, солонгос хоол зэрэг нь монголчуудын амьдралын нэг хэвшил боллоо. Залуус солонгос хэв загварыг дуурайж байна. БНСУ-ын олон улсын хөгжлийн агентлаг КОЙКА, хэл соёлоо сурталчилдаг “Сэжүн” институт /2 салбартай/ манай улсад үйл ажиллагаа явуулдаг, Засгийн газрын тэтгэлгээр жил бүр оюутнуудыг хүлээн авч сургаж байна. Улаанбаатарын их сургууль, “Хүрээ” дээд сургууль зэрэг Солонгосын хөрөнгө оруулалттай сургуулиуд Монголд олон жилийн турш үйл ажиллагаа эрхэлж ирлээ. Цаашлаад манай зарим иргэд Солонгос улсад олон жилээр ажиллаж амьдардаг, эргээд эх орондоо ирэхдээ тэд солонгос хэв загвар, амьдралын хэвшлийг орчиндоо түгээж байна. Манай улсын иргэдийн хамгийн олноороо зорьчдог улсын тоонд БНХАУ-ын дараа БНСУ хоёрдугаар байрт яваа юм.

Японы олон улсын хөгжлийн агентлаг ЖАЙКА, “Япон” сан зэргээр дамжуулж Япон улс бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт,

17. Дагийсүрэн Д. БНХАУ-аас Монгол Улсад 2000 оноос хойш үзүүлсэн буцалтгүй тусламж. Стратегийн судалгаа №67 (3/2014).

18. Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан мэдэгдэл. УБ., 2014.

“ЗӨӨЛӨН ХҮЧ”-НИЙ БОДЛОГО БА МОНГОЛ УЛС

соёл, урлаг, боловсролд чиглэсэн маш олон төсөл хөтөлбөрийг манай улсад хэрэгжүүлж байна. Сүүлийн жилүүдэд Японы Засгийн газрын тэтгэлгээр суралцуулах чиглэлд ихээхэн анхаарч ирсэн бөгөөд “1000 инженер”-ийг Японд бэлтгэх хөтөлбөр ажил хэрэг болоод явж байна. 2014 оны байдлаар Япон улсад 1548 оюутан суралцаж байсан бөгөөд үүний 68 нь Засгийн газрын тэтгэлгээр суралцаж байв. Энэ тоо цаашид ч өсөх хандлагатай байна.

Япон улс 1990 оноос хойш манай улсад хөгжлийн тусламж үзүүлэгч гол орон байсан бол одоо хөгжлийн зээл олгох, хамтын томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх эрмэлзэлтэй гэдгээ илэрхийлээд байгаа юм.

БНТУ-ын “Зөөлөн хүч”-ийг гадаад орнуудад хэрэгжүүлэгч Туркийн олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн агентлаг ТИКА-аар дамжуулан хийдэг бүтээн байгуулалтын ажлууд тогтмол хийгдэж байна. Турк хэлээр сургалт явуулдаг дунд сургууль Улаанбаатар хотоос гадна Дархан-Уул, Баян-Өлгий аймагт үйл ажиллагаа явуулж байна. Туркийн Засгийн газрын тэтгэлгээр тус улсад өдгөө 400 гаруй оюутан суралцаж байгаа бөгөөд жилд 50-60 оюутан суралцдаг ажээ.

Германы “Зөөлөн хүч”-ний 3 том тулгуур Гёте институт, Фридрих Эбертийн сан /МАН-д тулгуурлаж төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг/, Конрад Аденауэрийн сан /АН-тай хамтран үйл ажиллагаа явуулдаг/ манай улсад үйл ажиллагаагаа явуулж хэл соёл, улс төр, засаглалыг бэхжүүлэх чиглэлээр маш олон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

3. “Зөөлөн хүч”-ний бодлогын нөлөөллийг саармагжуулах асуудалд

Манай улсад гадны улсуудын “Зөөлөн хүч”-ний бодлого засаглалын хэлбэр, соёл урлаг, боловсрол, цахим систем, ажил хэргийн харилцаа буюу бизнесийн нөлөөллийн хэлбэрээр хэрэгжиж байна. Тэр дотроо боловсролын салбараар дамжуулан гадны улсууд хүч, нөлөөллөө тогтоох эрмэлзэл их болжээ. Ихэнх томоохон орнуудын боловсролын солилцооны хөтөлбөр манайх руу чиглэж, манай олон мянган залуусыг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулан өөрийн оронд сургаж байгаа аж. Монголчууд гадаадын өндөр хөгжилтэй оронд, тухайн улсын тэтгэлгээр суралцаж байгаа нь нэг талдаа манай улсын хэтийн

хөгжил дэвшилд тустай, хувь хүмүүсийн хөгжилд ч эерэгээр нөлөөлөх дэвшилтэй үзэгдэл. Гадаадад суралцсан монголчууд өөр өөрийн хэмжээгээр шинэ үзэл санаа, санаачилга тээж ирж, ажил амьдралдаа хэрэгжүүлэх нь бий. Иргэд хоорондын харилцаа холбоо ч өргөждөг. Үүнийг дагаад гадаадын хөрөнгө оруулалт, шинэ техник технологи Монголд орж ирдэг. Цаашид ч энэ байдал үргэлжлэх нь мэдээж.

Гэвч нөгөө талдаа тодорхой хэмжээний суралцагч сурч байсан орныхоо талаар эерэг сэтгэгдэлтэй үлдэнэ. Бодлого, үйл ажиллагаанд нь хүндэтгэлтэй ханддаг болно. Алсдаа тэр сэтгэлгээгээрээ асуудалд хандах, тэр нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд зарим талаар сөргөөр нөлөөлөх эрсдэл байгааг давхар бодолцох хэрэгтэй юм. Уламжлал, геополитикийн нөхцөл байдлаа ч бид бодох ёстой. Аль нэг талаар хэт бусад орны хараат байна гэдэг ямар ч улсад эрсдэлтэй байдаг. Хэчнээн ардчилсан, өглөгч өгөөмөр улс орон байлаа гээд түүний явуулж буй бодлогын цаана ашиг сонирхолгүй байна гэж байхгүй. Заавал эрх ашиг, зорилго нуугдаж байдаг нь хэнд ч ойлгомжтой асуудал. Тиймээс гадны орнуудын “Зөөлөн хүч”-ний бодлогод дүн шинжилгээ хийж, нөлөөллийг саармагжуулах арга хэмжээг одооноос авч эхлэх зайлшгүй шаардлага үүсчээ.

Өөрөөр хэлбэл, гадны орнуудын “Зөөлөн хүч”-ний бодлогын нөлөөлөл манай улсад бодитой болжээ. Үүнийг одоо хэрхэн саармагжуулах вэ?

Улс орнуудын туршлагаас харахад тухайлсан улс орнуудын бодлогод тус бүрт нь дүн шинжилгээ хийж,

- аливаа гадны нөлөөллийн бодлогыг тэнцвэржүүлж, саармагжуулах,
- зарим төрлийн хязгаарлалт тогтоох,
- үйл ажиллагаа явуулах шалгуурыг өндөр болгох,
- үзэл суртлын аян өрнүүлэх,
- өөрийн бодлогыг сэргүүлэн сурталчлах,
- хориг тавих зэрэг олон нөлөөллийн арга замыг хэрэглэдэг байна. Тухайлбал, Манай улсын хувьд Күнзийн институтын салбар нэмж байгуулахгүй, гадны хэвлэл мэдээллийн хэрэгсэлд

“ЗӨӨЛӨН ХҮЧ”-НИЙ БОДЛОГО БА МОНГОЛ УЛС

зөвшөөрөл өгөхгүй, ямар сан, хөтөлбөрүүд үйл ажиллагаа явуулах, ямыг нь хориглох юм гэдгийг шийдэх, телевизийн програм дахь гадаад нэвтрүүлэг, киноны цагийг багасгаж, хязгаарлах, үндэсний контент түлхүү нэвтрүүлэх зэрэг наад захын арга хэмжээнүүдийг авах боломжтой.

Цаашлаад гадны улсуудаас санал болгож буй зээл тусламж болгоныг аваад байх уу? Дэлхийн банк, ОУВС зэрэг байгууллагуудын чиглүүлсэн бодлого, өгсөн зөвлөмж болгоныг хэрэгжүүлээд явах уу? Хэнтэй найзлаж, нөхөрлөх вэ? зэрэгт төрийн тодорхой бодлоготой байх зүй ёсны шаардлага тулгарч байна. Тиймээс “Зөөлөн хүч”-ний бодлогод автахгүй үлдэх ямар арга замууд байгааг бодлогын түвшинд гүнзгийрүүлэн судлах хэрэгтэй юм.

Нөгөө талаар манай улсад нэг онцлог бий. Монгол Улс Гадаад бодлогын үзэл баримтлалдаа 2 хөршийн бодлогыг тэргүүн эгнээнд тавихаас гадна “Туравдахь ч хөршийн бодлого”-той байж тэнцвэртэй, эрх тэгш харилцааг эрхэмлэхээр заасан. Үүнийг “Зөөлөн хүч”-ний нөлөөг саармагжуулах, тэнцвэржүүлэхэд ашиглах явдал чухал байна.

Өөрөөр хэлбэл, энэхүү үзэл баримтлалд тулгуурлан цаашид гадны улс орнуудын нөлөөллийг тэнцвэржүүлэх бодлогыг хатуу барьж, аль нэг улсын бодлого давамгайлах үзэгдлийг улс төр, дипломатын аргаар зохицуулах шаардлага бий болсон байна.

ДУГНЭЛТ

Дэлхий дахинаа “Зөөлөн хүч”-ний бодлого нь улс төр, санхүү-эдийн засгийн хувьд чадамжтай орнуудын улс төрийн зорилгодоо хүрэх үүднээс гадаадын улс орнуудад өөрийн нөлөө, хүч чадлаа бэхжүүлэх хамгийн үр дүнтэй, өртөг зардал багатай арга хэрэгслийн нэг болжээ.

Монгол Улсын хувьд 20-р зууны дунд үеэс гадаад орнуудад улс орноо сурталчлах ажлуудыг /өнөөгийн “Зөөлөн хүч”-ний бодлого/ тасралтгүй хийж, дэлхий дахинд улс орноо чамлахааргүй хэмжээнд сурталчилсан, үүнийхээ үр дүнд НҮБ-д элсэх зэрэг зарим амжилтад хүрсэн уламжлалтай. XXI зуунд “Зөөлөн хүч”-ний бодлогын энэхүү уламжлалаа шинэ агуулга, санаачилгаар баяжуулж, илүү идэвхтэй ажиллах нь чухал байна.

Улс төр, эдийн засгийн хувьд нөлөө бүхий орон биш ч Монгол Улсад гадагшаа чиглэсэн өөрийн хэр хэмжээнд таарсан “Зөөлөн хүч”-ний бодлого явуулах нөөц бололцоо байгаа бөгөөд үүнд улс төр, дипломатын аргаас гадна, түүх, уламжлал, үндэсний өвөрмөгц өв соёл, шашин, шинжлэх ухаан, спортын ололт амжилт, уламжлалт болон орчин үеийн урлаг, хэвлэл мэдээлэл зэргийг өргөн хүрээнд ашиглах боломжтой юм.

Эхний ээлжинд энэхүү “Зөөлөн хүч”-ний бодлого нь улс орноо дэлхий дахинд эерэг, зөвөөр сурталчлах, төрийн бодлого, үйл ажиллагаа, түүх, соёл урлаг, өв уламжлалаа таниулах ач холбогдолтой бол цаашлаад өөрийн улсад ашигтай шийдвэрийг бусад улсаар гаргуулдаг гадаад бодлогын нөлөөллийн арга хэрэгсэл болох боломжтой юм.

Нөгөө талаар Монгол Улс нь гадаадын олон орны “Зөөлөн хүч”-ний бодлогын нөлөөлөлд автсан, цаашид ч автах эрсдэлтэй байна. “Зөөлөн хүч” нь Монголд бодитой хэрэгжиж буй АНУ, БНХАУ, ОХУ, БНСУ, Япон, БНТУ, ХБНГУ-ын бодлого, үйл ажиллагаа засаглалын хэлбэр, соёл урлаг, боловсрол, шашин, эдийн засгийн харилцаанд нөлөөлөхүйц хэмжээнд хүрчээ. Энэ нь алсдаа Монгол Улсын улс төр, нийгэм, эдийн засгийн салбарт гадны улс орнуудын бодлого давамгайлж, нөлөөлөл тогтох, улмаар Үндэсний аюулгүй байдалд аюул занал учруулах хэмжээнд хүргэх эрсдэлтэй юм. Иймд төр засгийн түвшинд гадны улс орнуудын “Зөөлөн хүч”-нд анхаарч, нөлөөллийг саармагжуулж, тэнцвэржүүлэх арга хэмжээг авах зайлшгүй шаардлага бий болжээ.

Эцэст нь дүгнэхэд, Монголын “Зөөлөн хүч”-ний бодлогын асуудлыг зөвхөн Засгийн газрын 4 жилийн хугацаатай хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлээд амжилт олох магадлал багатай. Тиймээс цаашид улс төрийн голлох намуудын мөрийн хөтөлбөрт тусгаж, УИХ-аар хэлэлцэн үзэл баримтлал болгон баталж, төрийн бодлогын хэмжээнд анхаарал тавьж урт хугацаанд, тасралтгүй хэрэгжүүлбэл өөрийн улсыг сурталчилж таниулах боломж талаасаа ч, гадны нөлөөллийг саармагжуулах арга хэрэгслээ зөв тодорхойлох талаасаа ч илүү их үр дүнд хүрэх боломж бүрдэх юм.

“ЗӨӨЛӨН ХҮЧ”-НИЙ БОДЛОГО БА МОНГОЛ УЛС

НОМ ЗҮЙ

1. Базардорж Д. Богдын дараагийн дүрийг тодруулах асуудалд. Рах Mongolica. №1. 2015.
2. БСШУЯ-ны статистик. УБ., 2013.
3. Бямбаханд Л. Монгол Улсын “Зөөлөн хүч”-ийг бий болгох боломж, АНУ-ын туршлага. Стратегийн судалгаа №63 (3/2013).
4. Дагийсүрэн Д. БНХАУ-аас Монгол Улсад 2000 оноос хойш үзүүлсэн буцалтгүй тусламж. Стратегийн судалгаа №67 (3/2014).
5. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992.
6. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Монгол Улсын төрийн бодлогын баримт бичгүүд. УБ., 2011.
7. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. Монгол Улсын төрийн бодлогын баримт бичгүүд. УБ., 2011.
8. Монгол Улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлого. Монгол Улсын төрийн бодлогын баримт бичгүүд. УБ., 2011.
9. Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр. УБ., 2016.
10. Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан мэдэгдэл. УБ., 2014.
11. Сант Марал. Улс төрийн барометр №15(49), 2016 оны 3 дугаар сар
12. Joseph S. Nye. Bound to Lead: The Changing Nature of American Power. New York., 1990.
13. Joseph S. Nye. Soft Power: The Means to Success in World Power. New York., 2004.
14. Цахим эх сурвалж:
15. Л.Пүрэвсүрэн: Монгол Улсыг түүх, урлаг соёл гэдэг зөөлөн хүчний бодлогоор дэлхийд сурталчилна., <http://sonin.mn/news/politics-economy/56832>
16. <http://www.meds.gov.mn/Ru1617>
17. <http://www.meds.gov.mn/chinaBachelor2016>, <http://www.meds.gov.mn/china MASDOC2016>
18. <http://www.beijing.mfa.gov.mn/>